



ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ



Х. МӨНХЗУЛ –ХЭҮК-ийн ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ РЕФЕРЕНТ

Агуулга

1. ХЭҮК-ын танилцуулга
2. Хүний эрхийн ерөнхий ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага
3. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал
4. Жендэрийн тэгш байдлын талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт
5. Жендэрийн ялгаварлан гадуурхалт
6. Жендэрт суурилсан хүчирхийлэл
7. Жендэрийн асуудлаарх гомдол шийдвэрлэх



“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт, хүн бүрт”

Хүний эрхийн Үндэсний Комиссын танилцуулга



ХЭҮБ-уудын тухай Парисын зарчим

- ▶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Парисын зарчим”-ыг батлан гаргасан.

Парисын зарчмаар “олон улсын гэрээ, конвенцид заасан **хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг** хүлээн зөвшөөрч, түүнийг **хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжих** үүрэг бүхий Хүний эрхийн үндэсний байгууллагыг **байгуулах**”-ыг гишүүн орнуудад уриалсан.



Хүний эрхийн Үндэсний Комисс

- ▶ Улсын Их Хурал 2000 оны 12 дугаар сарын 07-ны Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг батлав.
- ▶ Комиссын гишүүд 2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр тангараг өргөснөөр Комиссын бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн байна.

Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд **хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих** байгууллага мөн.



Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм

Төрийн механизм

Бие
даасан
механизм

Туслах
механизм

Улсын Их Хурал

Ерөнхийлөгч

Үндсэн хуулийн
Цэц

Засгийн газар,
яамд, агентлаг,
газрууд

Шүүх эрх мэдлийн
байгууллагууд

Хүний
эрхийн
Үндэсний
Комисс

Нутгийн
өөрөө
удирдах
ёсны
байгууллага

Иргэний
нийгэм

Төрийн хүлээх үүрэг



Хүндэтгэх

(улсууд эрхийг зөрчдөг аливаа үйлдлээс татгалзах ёстой)



Хамгаалах

(төр нь эрхэд халдсан төрийн бус этгээдийн зүй бус үйлдлээс хүн бүрийг хамгаалах үүрэгтэй)



Хангах

(улсууд хүн бүр өөрийн эрхийг эдэлж чадахыг баталгаажуулах эерэг үйлдлийг хийх ёстой – улсууд хууль, бодлогыг баталж, эрхүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах ёстой)




ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА ГЭЖ ЮУ ВЭ?

Хүний эрхэд суурилсан хандлага бол **хүн төвтэй** хандлага”. Энэ нь хүний эрхийн олон улсын стандартууд, зарчмуудад үндэслэдэг.

Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй бол эрх зүйн хэм хэмжээ нь олон улсын хүний эрхийн стандартад суурилж, үйл ажиллагаа нь **хүний эрхийг хөхиүлэн дэмжиж, хамгаалахад** чиглэдэг хүний хөгжлийн үйл явцын үзэл баримтлалын хүрээ юм.

Аюулгүй байдлыг хангахгүйгээр хөгжлийн үр шимийг хүртэхгүй, хөгжилгүйгээр бид аюулгүй байдлыг бүрдүүлэхгүй, хүний эрхийг хүндэтгэхгүйгээр хөгжлийн ч тэр, аюулгүй байдлын ч тэр аль алины үр шимийг хүртэж чадахгүй...

Кофи Аннан, НҮБ-ын ЕНБД асан, 2005



ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, ХУУЛЬ ДҮРЭМ БОЛОВСРУУЛАХДАА


Хүний эрхийн зарчим	Төрийн үүрэг	Иргэдийн оролцоог хангах





“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт, хүн бүрт”

Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал



Эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх хөдөлгөөн

Элизабет Кэди Стэнтон
1848 оны 7 дугаар сарын 13-
нд Эмэгтэйчүүдийн эрхийн
төлөөх хөдөлгөөнийг албан
ёсоор эхлүүлсэн. (АНУ)



”Уян сэтгэлтнүүдийн тунхаглал”

- ▶ Эмэгтэйчүүд гэрлэсний дараа ямар нэгэн эрх мэдэлгүй болдог
- ▶ Эмэгтэйчүүд сонгуульд саналаа өгөх эрхгүй
- ▶ Гэрлэсэн эмэгтэйчүүд өмчлөх эрхгүй
- ▶ Эр нөхрүүдэд эхнэрээс давсан эрхийг олгож, хүчирхийлэх, зодоход хууль үйлчилдэггүй
- ▶ Гэр бүл салалтын асуудалд эрчүүдэд илүү эрх олгосон
- ▶ Ихэнх ажил мэргэжил эмэгтэйчүүдэд хаалттай, эрчүүдтэй адил цалин хөлс авдаггүй
- ▶ Эмэгтэйчүүдэд анагаах, хууль эрх зүйн чиглэлээр суралцах эрхгүй
- ▶ Их сургуульд эмэгтэйчүүд элсэн суралцаж чаддаггүй
- ▶ Эмэгтэйчүүд сүмд элсэх эрхгүй

“Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах нь”

“Эмэгтэй хүнийг эр нөхрийнхээ хайр ивээлд байх ёстой уян эмзэг сэтгэлтэй, хөөрхөн, дур булаам харагддаг торон доторх шувуу гэж үздэг хэвшмэл хандлагыг өөрчлөхгүйгээр бид оюун санааны хөгжил дэвшилд хүрч чадахгүй”

- Мэри Волстонкрафт

A
VINDICATION
OF THE
RIGHTS OF WOMAN:
WITH
STRICTURES
ON
POLITICAL AND MORAL SUBJECTS:
BY MARY WOLLSTONECRAFT.



PRINTED AT BOSTON,
BY PETER EDES FOR THOMAS AND ANDREWS,
FAUST'S Statue, No. 45, Newbury-Street,
MDCCLXIII.

Жендэрийн ялгаатай үнэлэмж, хэвшмэл ойлголтыг бүрдүүлдэг, бэхжүүлдэг соёлын институцүүд

Дасгал ажил: Хэвшмэл ойлголт хэрхэн бүрэлддэг, үүнийг өөрчлөн хувиргах /сонгох/

- Хэлц үг, өвөрмөц хэллэг, аман яриа
- Дуу
- Савангийн дуурь, драм, ардын урлаг
- Шашин
- Соёл, зан заншил
- Боловсрол
- Хэвлэл мэдээлэл




- ▶ АНУ-ын Үндсэн хуулийн 19 дэх нэмэлтээр эмэгтэйчүүдэд сонгуулийн эрх олгосон. (1920)

19th Amendment to the Constitution


1920

The right of citizens of the United States to vote shall not be denied or abridged by the United States or by any State on account of sex.



Тодорхойлолт:


- ▶ Жендэрийн тэгш байдал гэдэг нь эмэгтэй эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ **эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх, оролцоотой байж, хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдахыг хэлнэ.**



EQUALITY

Жендэрийн тэгш байдал нь:

Эмэгтэйчүүд,
эрэгтэйчүүдийг
бүх зүйлээр
адилхан болгох




Эмэгтэй, эрэгтэй
хүний эрх, үүрэг,
хариуцлага,
боломж нь
хүйсийн ялгаанаас
хамаарахгүй байх

Жендэрийн тэгш
байдал нь
эмэгтэйчүүд бус
эрэгтэйчүүдэд ч
хамааралтай


Хүйсийн буюу бие
махбодийн хувьд
өөр хоорондоо
ялгаатай болохыг
хүлээн зөвшөөрөх

Хүйсийн ялгаанд нийцүүлэн
хоёулангийнх нь хүсэл
сонирхол, хэрэгцээг
харгалзан үзэх

FOR A FAIR SELECTION
EVERYBODY HAS TO TAKE
THE SAME EXAM: PLEASE
CLIMB THAT TREE




- ▶ Жендэрийн тэгш байдал гэх ойлголт нь хүн төрөлхтөний оюун санааны хөгжлийн явцад бий болсон үнэт зүйл юм.



Gender mainstreaming

- ▶ Жендэрийн тэгш байдлыг бодлогоор дэмжих үйл явц - **gender mainstreaming**.
- ▶ Аливаа улс орон өөрийн хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо жендэрийн асуудлыг уг бодлогод тусгах замаар жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалын загварыг хөгжүүлсээр ирсэн.
- ▶ Gender mainstreaming нь аливаа салбарын бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомж болон хөтөлбөр, төслийн үйл ажиллагааны үр дүн эрэгтэй, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байгааг үнэлдэг.



Эдийн засгийн чиг
баримжаа бүхий хөгжлийн
бодлого
(1960-1970)

- **Эдийн засгийн хөгжлийн үр дүнд** нийгэмд тэгш байдал хангагдана гэж үзэж байсан.
- Гэвч ядуурал, баян хоосны ялгаа ихэсч, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь ганхсан.

Эмэгтэйчүүд хөгжилд
хандлага(1970-1980)

- Аливаа **хүн хөгжлийн үр шимийг хүртэхээс гадна түүнийг бий болгоход оролцогч байх ёстой** гэж үзэх болсон.
- Тэр дундаа нийгэм дэх **эмэгтэйчүүдийн оролцоо, байр суурийг нэмэгдүүлэхэд** тусгайлан анхаарах бодлого баримталж байсан.

Жендэр ба хөгжил хандлага
(1980-аад оноос хойш)

- Нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй **хүмүүсийг тэгш боломжоор хангахад чиглэсэн бодлого.**
- Эмэгтэйчүүдийг бүлгийн хувьд **онцлон авч үздэггүй.**
- Жендэрийн хувьд тэгш хөгжлийг бий болгоход эмэгтэй эрэгтэй хүмүүсийн оруулах хувь нэмрийг чухалчлан үздэг

Эмэгтэйчүүд
хөгжилд
(Women in
Development)

Жендэр ба
хөгжил
(Gender and
Development)

Global Gender Gap Report 2014, 2017



Жендэрийн тэгш байдлын талаарх эрүүл мэнд, боловсрол, улс төр, эдийн засгийн үзүүлэлт

1	Исланд	0.8594
2	Финланд	0.8453
3	Норвеги	0.8374
4	Швед	0.8165
5	Дани	0.8025
41	Мадагаскар	0.7214
42	Монгол	0.7212
43	Казахстан	0.7210

1	Исланд	0.878
2	Норвеги	0.830
3	Финланд	0.823
4	Рванда	0.822
5	Швед	0.816
52	Казахстан	0.713
53	Монгол	0.713
43	Хорват	0.711

Хүний эрхийн олон улсын билл

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

ЭРҮҮДЭН
ШҮҮХИЙН ЭСРЭГ
КОНВЕНЦ

ИРГЭНИЙ БОЛОН
УЛС ТӨРИЙН
ЭРХИЙН ТУХАЙ
ОЛОН УЛСЫН ПАКТ

ЭДИЙН ЗАСАГ,
НИЙГЭМ, СОЁЛЫН
ЭРХИЙН ТУХАЙ
ОЛОН УЛСЫН ПАКТ

ХҮҮХДИЙН ЭРХИЙН
ТУХАЙ КОНВЕНЦ

АРЬС ҮНДСЭЭР
ЯЛГАВАРЛАН
ГАДУУРАХ БҮХ
ХЭЛБЭРИЙГ УСТГАХ
ТУХАЙ КОНВЕНЦ

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ
АЛАГЧИЛАХ БҮХ
ХЭЛБЭРИЙГ УСТГАХ
ТУХАЙ КОНВЕНЦ

ХҮЧЭЭР СУРАГГҮЙ
АЛГА БОЛГОХООС БҮХ
ХҮНИЙГ ХАМГААЛАХ
ТУХАЙ КОНВЕНЦ

ЦАГААЧ АЖИЛЧИД
ТЭДГЭЭРИЙН ГЭР
БҮЛИЙГ ХАМГААЛАХ
ТУХАЙ КОНВЕНЦ

ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН
ТУХАЙ КОНВЕНЦ




Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай КОНВЕНЦ

1979 оны 12 сарын 18 нд батлагдаж, 1981.09. 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

- ▶ Эмэгтэйчүүдийн бүх талын эрхийг хамгаалж дэлгэрэнгүй хуульчилсан төдийгүй эмэгтэйчүүдийн эрхийн талаарх философийн үндсийг хангаж өгсөн.
- ▶ Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төрийн үүрэг, хариуцлагыг тогтоосон байна.

Монгол Улс энэхүү Конвенцод 1981 онд, түүний Нэмэлт Протоколд 2001 онд нэгдэн орсон ба Конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, Конвенцод заасан хугацаанд тайлагнах, үндэсний хууль тогтоомжоо уг Конвенцийн агуулга, шаардлагад нийцүүлэх үүргийг хүлээдэг.



189 орон нэгдэж орсон бол Ватикан, Иран, Сомали, Судан, Тонга улсууд нэгдэн ороогүй байна.

Ираны жишээ

- ▶ Эмэгтэйчүүд гудамжинд хижаб буюу нүүрээ халхалсан тор зүүж явна.
- ▶ Эр нөхрөөсөө өөр хүнтэй унтсан (зина) чулуугаар цохиж алах ял шийтгэнэ.
- ▶ Анхны эхнэрээсээ зөвшөөрөл хүсэхгүйгээр хоёр дахь эхнэртэй болох эрх.



Монгол Улсын үүрэг хариуцлага

- ▶ Монгол Улс энэхүү Конвенцод 1981 онд, түүний Нэмэлт Протоколд 2001 онд нэгдэн орсон ба энэхүү Конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, Конвенцод заасан хугацаанд тайлагнах, үндэсний хууль тогтоомжоо уг Конвенцийн агуулга, шаардлагад нийцүүлэх үүргийг хүлээдэг.

Конвенцийн хэрэгжилтийн тайлан:

- ▶ Анхны илтгэл 1983
- ▶ Хоёр дахь илтгэл 1987
- ▶ Хамтатгасан гурав, дөрөв дэх илтгэл 1997
- ▶ Хамтатгасан тав, зургаа, долоо дахь илтгэл 2007
- ▶ Хамтатгасан найм, ес дэх илтгэл 2014
- ▶ Арав дахь илтгэл 2020

НҮБ-ын ЭЯГБХУХороо

- ▶ 23 бие даасан эксперт
- ▶ Конвенцийн хэрэгжилтийн тайланг оролцогч улсуудаас хүлээн авч үнэлж дүгнэх, зөвлөмж өгөх үүрэгтэй.
- ▶ Гомдлын дагуу эрх зөрчигдсэн эсэхийг шалгана.
- ▶ Тус хорооны анхны даргаар Монгол Улсын иргэн Лувсанданзангийн Идэр 1982-1987 онд ажиллаж байв.





“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт, хүн бүрт”

Жендэрийн ялгаварлан гадуурхалт ба жендэрт суурилсан хүчирхийлэл



Жендэрийн ялгаварлан гадуурхалт

Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт:

- ▶ эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж,
- ▶ гэрлэлтийн байдлаар нь
- ▶ ялгаварлах,
- ▶ үгүйсгэх,
- ▶ хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүй



Шууд
ялгаварлан
гадуурхалт

- Адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдэл

Шууд бус
ялгаварлан
гадуурхалт

- Хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг;
- **Зорилго агуулаагүй**
- **Бодит амьдрал дээр** эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан үр дагаварт хүргэдэг
- Шууд бус ялгаварлан гадуурхалт түгээмэл боловч нүдэнд үзэгдэхгүй болтлоо нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг тул түүнийг илрүүлж, устгах нь амаргүй байдаг.

“Юуг жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж үзэхгүй бэ

- ▶ Зөвхөн нэг хүйсийн онцлог хэрэгцээнд зориулсан эрүүл мэнд, боловсролын зэрэг төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх
- ▶ Оюутан, суралцагчдын дотуур байр, эмнэлэг, асрамж, амралт, сувилал, хорих болон түр саатуулах газар, эрүүлжүүлэх байранд хүйсээр нь ялган байрлуулах
- ▶ Аль нэг хүйсийн гишүүнчлэл бүхий олон нийтийн ба төрийн бус байгууллага байгуулах
- ▶ Зөвхөн нэг хүйсийн хүмүүсийг хамруулсан урлаг, спортын арга хэмжээ зохиох
- ▶ Тухайн ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалж ажилд авахдаа зөвхөн нэг хүйсийн хүнийг сонгох

Жендэрт суурилсан хүчирхийлэл

- ▶ “Жендэрээс үүдэлтэйгээр бусдад
- ▶ **Бие махбодийн**
- ▶ **Бэлгийн**
- ▶ **Сэтгэл санааны гэм хор**
- ▶ **Эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй**

Жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд



- ▶ Хүн худалдаалах
- ▶ Ажлын байрны бэлгийн дарамт
- ▶ Гэр бүлийн хүчирхийлэл
- ▶ Бэлгийн хүчирхийлэл гм



“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт, хүн бүрт”

Жендэрийн асуудлаарх гомдол шийдвэрлэх процесс




Хэн гомдол гаргах

- Хувь хүн
- Үйлдвэрчний эвлэл
- Олон нийтийн байгууллага

Хаана гомдол хандах

- Хүний эрхийн Үндэсний Комисс
- Хууль хяналтын байгууллага
 - Иргэний хэргийн шүүх
 - Цагдаагийн байгууллага

Гомдол хянан шийдвэрлэх



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
Хүний эрхийн Үндэсний Комиссын
www.nhrctm.gov.mn
цахим хуудсанд хандана уу